

**Монгол Улс**  
**НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Ховд аймгийн**  
**хувийн хэвшлийн байгууллагуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт**  
**2017 оны 9-р сарын 20**

*Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл [ibaatarkhuu@worldbank.org](mailto:ibaatarkhuu@worldbank.org) и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.*

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодол сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 20-нд Ховд аймгийн хувийн хэвшлийн 11 байгууллагатай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p><b>Улс орны хөгжлийн дүн шинжилгээний талаарх санал (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)</b></p>	<p><b>Боломж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Чингис бонд нь улс орны хөгжилд богино хугацаанд чухал үүрэг гүйцэтгэсэн боловч тус бондын хөрөнгөөр санхүүжсэн төслүүд нь тогтворгүй эсвэл улс оронд урт хугацааны хөгжил авчраагүй юм.</li> <li>• Орон нутгийн хөгжлийн сан нь маш үр ашигтай. Төвлөрлийг сааруулах нь орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжихэд их нөлөөтэй.</li> <li>• Өнгөрсөн жилүүдэд уул уурхайн салбарын хөгжил, бонд гаргасан, дэд бүтцийн хөгжил зэрэг нь иргэдийн амьжиргааг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн.</li> <li>• Аялал жуулчлалын салбар мэдээлэл технологи, сошиал нийгмийн сүлжээний хөгжлөөс их үр ашиг авсан.</li> </ul>
	<p><b>Сорилт:</b></p> <p><b>Хөдөө аж ахуй болон мал аж ахуй:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Малын өвчлөл нь өнөө үед том асуудал болоод байна. Хэрэв энэ асуудлыг шийдвэл Монгол улс махны экспортоос ихээхэн ашиг олох боломжтой. Иран, БНХАУ болон бусад орнууд Монголоос мах импортлох сонирхолтой байгаа. Ховд аймгийн хэмжээнд нядалж болох махныхаа зөвхөн 5 хувийг л одоо нядалж байгаа. Малын өвчлөлөөс болж манай махны экспорт хоригт ордог, жишээ нь сая гарсан өвчний дэгдэлтээс болж махны экспортыг 5 жилийн хугацаанд хорилоо. Тийм</li> </ul>

учраас Засгийн газар малын эрүүл мэндийг сайжруулах хөтөлбөрүүд дээр ажиллах хэрэгтэй.

- Хэрэв мах боловсруулалт сайжирвал бусад мах махан бүтээгдэхүүний үнэ өснө.
- Монголын дотоодын хэрэглээ, зах зээл хязгаарлагдмал тул экспортыг дэмжих хууль эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй.
- Үр тариа, хүнсний ногооны агуулах хангалттай байдаггүй. Цаг агаарын эрс тэс нөхцлөөс болж хүнсний ногоог зөвхөн зуны улиралд ургуулж, удаах 2 сарын хугацаанд борлуулдаг. Хүнсний ногооны агуулах бариснаар дотоодын ногоог илүү удаан хугацаанд хэрэглэх боломж нээгдэнэ. Энэ нь мөн хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндтэй мөн холбоотой, учир нь буруу хадгалсан тариа ногоо нь хүний биед хортой юм.

#### **Уул уурхайн салбар:**

- Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь улс орны хөгжлийн түлхүүр юм. Байгалийн баялгийг зөв зохистой удирдлага, Монгол улсын ирээдүйн илүү их хөгжил дэвшил рүү хөтөлнө.
- Ихэнх аймагт уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа боловч уул уурхайн салбарт ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэндийн талаар судалгаа, шинжилгээ байдаггүй. Уул уурхайд ажилладаг хүмүүс төрөл бүрийн химийн бодист өртөж, бага хүчил төрөгчтэй орчинд ажилладаг. Уул уурхайн салбарт ажиллаж буй хүмүүсийн тоо их байгаа болохоор эдгээр хүмүүсийн ажиллах орчины тэдний эрүүл мэндэд урт болон богино хугацаанд үзүүлж буй нөлөөллийг судлах хэрэгтэй. Судалгаагаар мөн аливаа өвчлөл дараачийн үедээ залгамжлагдах байдлыг судлавал зүйтэй. Энэ судалгааг бүс нутгийн хэмжээнд эсвэл тодорхой газруудыг түүвэр болгон сонгож хийх боломжтой.
- Ховд аймагт томоохон хэмжээний уул уурхайн төслүүд ашиглалтанд ороход бэлэн болоод байна. Тэдний үйл ажиллагаа эхлэхээс өмнө байгаль орчин, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг хийх хэрэгтэй. Ховд аймагт байрлах Хөшөөтийн уурхайд ажилладаг хүмүүс тогтмол эрүүл мэндийн үзлэгэд ордог. Гэсэн хэдий ч шинэ уурхайнуудад ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэндийн байдлыг тогтмол хянах асуудал нээлттэй хэвээр байна.
- Орон нутгийн иргэд тухайн газар нутагт байгаа уул уурхайн үйл ажиллагаанаас ашиг хүртэхгүй байна. Жишээ нь Ховдын иргэд Ховдод байрлах Хөшөөтийн уурхайгаас шууд үр ашиг хүртдэггүй.

#### **Аялал жуулчлал:**

- Дэд бүтцийн хөгжлийг дагаар баруун бүст ирэх жуулчдын тоо жил бүр нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч Ховдод жуулчдад зориулсан бусад үйлчилгээ, бүтээгдэхүүнүүд хөгжөөгүй. Олон тооны жуулчид Ховдоор дамжин өнгөрдөг боловч орон нутгийн багтаамжнаас шалтгаалан тэдний цөөн хэсэг нь л аймагт цаг өнгөрүүлдэг.

- Аялал жуулчлалын салбарыг илүү цогцоор нь авч үзэх хэрэгтэй. Зочид буудал, банк санхүүгийн үйлчилгээ, логистикийн компаниуд болон жижиглэнгийн худалдааг хөгжүүлэх бодлого, бусад дэмжлэг хэрэгтэй.
- Монгол улсад бүс нутгийн хөгжлийн бодлогыг цааш хөгжүүлэх хэрэгтэй. Ховд аймаг Улаанбаатараас алс хол байрладаг нь аймгийн хөгжилд тушаа болдог. Мөн Ховдод том хэмжээний уул уурхайн төсөл байхгүй. Хөгжлийн хөтөлбөрүүд нь орон нутгийн хөгжлийн онцгүй хэрэгцээ шаардлагад нийцсэн байх хэрэгтэй.

#### **Эрүүл мэнд:**

- Ховд аймагт өвчлөл ерөнхийдөө өндөр байдаг.
- Агаарын бохирдол нэмэгдэж байна. Агаарын чанар муу байгаагаас хүмүүсийн өвчлөл мөн нэмэгддэг. Иймээс ногоон хөгжлийн бодлогыг баримтлах хэрэгтэй.
- Хүнсний аюулгүй байдал нь иргэдийн эрүүл мэнд, сайн сайханд чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Хөдөө орон нутгийн иргэд, малчдын эрүүл мэнд маш муу байгаа ч энэ асуудлыг орхигдуулсан.

#### **Байгаль орчин:**

- Бус нутагт мод тарих, ногоон байгууламж бий болгох төслүүд ер хэрэгжээгүй. Зүүн аймгуудад ийм төрлийн хөтөлбөрүүд нэлээд хэрэгжсэн ба үр дүн нь илэрхий байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг хянахад улам хэцүү болж байна, элсэн шуурга, цөлжилт эрчимтэй нэмэгдэж байна.
- Агаарын бохирдол том асуудал болж байна. Шинэ дулааны цахилгаан станц баригдсан ч хувийн орон сууцны барилгууд төвийн шугам, дулаанд холбогдоогүй байна.

#### **Хувийн хэвшлийн хөгжил:**

- Үйлдвэр, жижиг бизнесүүдийг илүү сайн судалгаа, зохицуулалт хийж байж хөгжүүлэх хэрэгтэй. Нэг чиглэлээр хэтэрхий олон компани үйл ажиллагаа явуулахаар бүгдийх нь ашиг буурдаг.
- Ядуурлыг бууруулахын тулд Монголд ЖДҮ-үүд болон хувийн хэвшлийг дэмжих хэрэгтэй.
- Хувийн хэвшлийн байгууллагууд хөрөнгө нөөц дутагдалтайгаас болж ажилчдынхаа чадавхийг дээшлүүлэхэд хөрөнгө зарцуулдаггүй.
- Өндөр технологи бүхий тоног төхөөрөмж нь өндөр үнэтэй байдаг тул хувийг хэвшил тэдгээрийг авахад мөн хөрөнгө санхүүгийн дэмжлэг хэрэгтэй.

#### **Бусад:**

- Сүүлийн үеийн технологийн дэвшил, хандлагын талаар мэдээлэл муу байдаг. Орон нутгийн иргэдэд мөн орон нутгийн хөгжлийн боломж, зах зээлийн талаар мэдээлэл, судалгаа байдаггүй.
- Олон боловсролтой иргэд Улаанбаатар луу явж ажиллаж байгаагаас оюуны шүүрэл болж байна.
- Худалдан авах ажиллагааны тухай хууль нь орон нутгийн нөхцөл байдалд сайн тохироогүй. Орон нутгийн нөхцөл байдалд тааруулан сонголт хийхэд шаардлага шалгуур нь хэтэрхий уян хатан биш байдаг. Орон нутгийн компаний чадавх үргэлж тухайн тендерт тавигдсан шаардлагаас доогуур байдаг. Орон нутгийн түвшинд худалдан авах ажиллагааны менежмент, удирдлага мөн тааруу байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагаа бүх иргэдэд ил тод байдаггүй. Сангийн зарлагыг нээлттэй, тодорхой тайлагнадаггүй.
- Бүс нутаг дахь эрчим хүчний хангамж асуудалтай хэвээр байна, эрчим хүчийг үнэ төлбөргүй авах хэрэгтэй.

#### **Банк, санхүү:**

- Арилжааны банкууд уг салбарыг монопольдсноор бусад оролцогч нарыг шударгаар өрсөлдөх боломжийг хааж байна.
- Барьцаа хөрөнгийг зохих үнэ цэнэнээс нь доогуур үнэлж байна. Жишээ нь, барьцаа хөрөнгийн бодит үнийх нь 15 хувиар үнэлдэг.
- Зээлийн хүү хэтэрхий өндөр байгаа нь жижиг бизнесүүдийн хөгжлийг сааруулж буй томоохон хүчин зүйл юм. Банкны зээлийн бодлогыг сайжруулах хэрэгтэй.
- Бизнесүүдэд санхүүжилт олох боломж хязгаарлагдмал байна. Арилжааны банкну олон эзэд болон тэдний хамсаатнууд төрд ажиллан, бизнесүүдэд том хэмжээний зээл олгохоос Засгийн газарт зээл олгохыг илүүд үздэг.

#### **Боловсролын салбар:**

- Аймгуудад өндөр боловсролтой мэргэжилтнүүд хангалттай байдаггүй.
- Их дээд сургууль төгсөгчид олон байгаа боловч ур чадвартай техникийн мэргэжилтнүүд хомс байна. Жишээ нь, тарвас тариалж байгаа хүмүүс бордоог хэрхэн зөв ашиглахаа мэддэггүй бөгөөд бордоог буруу ашигласнаас үүдсэн хоолны хордлого гарч байсан.
- Дунд сургуулийн чанар сайн биш. Багш нар цалин нэмэхийг шаардаж байгаа боловч тэдний үзүүлж буй үйлчилгээг зөв зохистой үнэлээгүй байна.
- Багшийн хөгжлийн асуудлыг орхигдуулсан ба багш нарыг сайн бэлтгээгүй байна.

#### **Засаглал:**

	<ul style="list-style-type: none"> <li>• Авлигал, хүнд суртал өндөр байна. Хүчин төгөлдөр хуулиуд хоорондоо зөрчилдөөнтэй байдаг. Монголд улс төрийн шинэтгэл хийх шаардлагатай.</li> <li>• Төрийн албан хаагчид тухайн ажилдаа шаардлага хангадаггүй. Дөрвөн жил болгон төрийн албан хаагч нар солигдон, төрийн албаны тогтворгүй байдлыг үүсгэж байгаа нь чадавхийг бууруулж, Засгийн газрын тогтвортой үйл ажиллагааг алдагдуулж байна.</li> <li>• Хөрөнгө оруулалтын төслүүдийн үр ашиг сайн харагдахгүй байна. Хөрөнгө оруулалтыг ихэвчлэн олон салбарт бага багаар хуваарилж, аль ч салбар бусдаасаа илүү гарч сайжирсан зүйлгүй. Хөтөлбөрүүд нь зорилтот үр ашиг хүртэгчдээ хүрч чадахгүй байна.</li> <li>• Засгийн газар нь хөгжлийн болон бусад санхүүжилтийн ихээхэн хувийг засаглалыг сайжруулахад зарцуулсан боловч энэ тал дээр үр дүн төдийлөн харагдахгүй байна. Ийм учраас засаглалын асуудлыг дахин онцолж гаргах шаардлагатай эсэхэд зарим оролцогчид эргэлзэж байв.</li> </ul>
<b>ДБГ-ийн стратеги, түншлэлийн талаарх санал</b>	<b>Салбарууд:</b> <ul style="list-style-type: none"> <li>• ДБГ нь Монгол улсад (i) хөдөө аж ахуй, (ii) хүний хөгжил (боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал), (iii) байгаль орчин, (iv) дэд бүтэц (эрчим хүч, цахилгаан, сэргээгдэх эрчим хүч), (v) засаглалын салбарыг хөгжүүлэхэд голлон анхаарч дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.</li> <li>• Хөдөөгийн хөгжил, хөдөө аж ахуйн салбарт өмнөх амжилт, туршлага дээрээ тулгуурлан энэ салбарыг түлхүү дэмжих хэрэгтэй (жишээ нь, малын индексжүүлсэн даатгалын төсөл).</li> <li>• Засаглалын салбарыг дэмжиснээр илүү их хөрөнгийг засгийн газарт зарцуулан, үүнээс үр дүн төдийлөн гардаггүй тул зарим оролцогчдын зүгээс засаглалыг бэхжүүлэх чиглэлээр дахин дэмжлэг үзүүлэх хэрэгтэй эсэхэд эргэлзэж байв.</li> <li>• Нэг оролцогч яагаад ДБГ-ийн зүгээс эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлж байгаагүйг асуув.</li> </ul>

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултаудаас 5 хүртэлх хариулыг сонгоно уу)

— Төрийн удирдлага/шинэтгэл	7	64%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	7	64%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	5	45%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	5	45%
— Санхүүгийн зах зээл	4	36%
— Авлигатай тэмцэх	3	27%
— Эрүүл мэнд	3	27%

— Боловсрол	2	18%
— Байгалийн нөөцийн удирдлага	2	18%
— Хөдөөгийн хөгжил	2	18%
— Эдийн засгийн өсөлт	2	18%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	2	18%
— Хүнсний аюулгүй байдал	2	18%
— Гадаадын хөрөнгө оруулалт	2	18%
— Зам, тээвэр	2	18%
— Гамшгийн эрсдэлийн удирдлага	1	9%
— Эрх тэгш боломжоор хангах	1	9%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	1	9%
— Бусад	1 (хууль, эрх зүй)	9%
— Худалдаа, экспорт	0	0%
— Хотын хөгжил	0	0%
— Нийгмийн хамгаалал	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Ус, ариун цэврийн байгууламж	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хүний хөгжлийг дэмжих	8	73%
Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	8	73%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	7	64%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	6	55%
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	3	27%
Бүгд чухал	1	9%